

## Чуулга уулзалтыг ивээн тэтгэх гэрээ

2011 оны ..... дугаар  
сарын .....-ны өдөр

№

Улаанбаатар хот

Энэхүү хамтран ажиллах гэрээ /цаашид “гэрээ” гэх/-г нэг талаас “Эрдэс Баялаг Уул Уурхайн Бирж” /цаашид “гүйцэтгэгч” гэх/, нөгөө талаас ..... ХХК, ХК /цаашид захиалагч гэх/ /хамтад нь “талууд” гэх/ харилцан тохиролцож зөвшөөрснөөр энэхүү гэрээг байгуулав.

### Нэг. Ерөнхий зүйл

1.1 Энэхүү гэрээний зорилго нь Монгол Улсын Иргэний хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн Захиалагч тал нь олон улсын шинжтэй хурал зөвлөгөөнийг ивээн тэтгэх, өөрийн үйл ажиллагаагаа бусдад сурталчлан таниулахад оршино.

### Хоёр. Гэрээний хугацаа

2.1 Энэхүү гэрээг 2011 оны .....сарын .....-ны өдрөөс эхлэн 2011 оны .....сарын .....-ний өдөр хүртэл хугацаанд байгуулав.

2.2 Захиалагч нь энэхүү гэрээнд Плантинум, Голд, Силвер /доогуур нь зурах/ спонсорлоор оролцоно.

2.3 Энэхүү гэрээний нийт мөнгөн дүн..... байна.

2.4 Гэрээнд хоёр тал гарын үсэг зурж хүчин төгөлдөр болсноос хойш ажлын 3 хоногийн дотор захиалагч тал 2.2-т заасан төгрөгийг гүйцэтгэгчийн дансанд шилжүүлнэ.

### Гурав. Захиалагчийн эрх, үүрэг

3.1 Захиалагч нь тухайн багцад тохирсон үйлчилгээг /хавсралт/ заасан хугацаанд гүйцэтгүүлэх эрхтэй.

3.2 Захиалагч нь Гүйцэтгэгчээс энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.

3.3 Захиалагч нь энэхүү гэрээний бусад хэсэгт заасан эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.

### Дөрөв. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

4.1 Гүйцэтгэгч нь Захиалагчид нийлүүлэх үйлчилгээг чанартай, хэвлэл мэдээлэл, самбар дээр байрлах захиалагчийн талаарх мэдээллийг утга найруулга сайтай, алдаагүй, хэвлэлийн технологийн шаардлага хангасан түвшинд хэвлэн, улмаар байрлуулна.

4.2. Энэхүү гэрээний хугацаанд Гүйцэтгэгч захиалгын үнэ тарифыг нэмсэн, өөрчилсөн тохиолдолд Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний хугацаанд Захиалагчид тухайн заасан үнээр нийлүүлнэ..

4.3 Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний бусад хэсэгт заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

### Тав. Хариуцлага

5.1 Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний 4.1-т заасны дагуу Захиалагчийн хүссэн хэмжээнд шаардлага хангаагүй түвшинд хэвлэн нийтэлсэн тохиолдолд үнийн дүнг бууруулна.

5.4 Хэрвээ Захиалагч тал гаргаж өгсөн хуваарийн дагуу болон гэрээ хийснээс хойш үйлчилгээг үзүүлээгүй бол гэрээг захиалагч тал цуцлах эрхтэй.

### Зургаа. Төлбөр тооцоо

6.1 Гүйцэтгэгч нь ивээн тэтгэх гэрээ хийсэн өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор нэхэмжлэхийг Захиалагчид хүргүүлнэ.

6.2 Захиалагч нь бүтээгдэхүүний чанарыг магадлан үзээд нэхэмжлэхийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 3 өдрийн дотор үйлчилгээний төлбөр тооцоог “Эрдэс Баялаг Уул Уурхайн Бирж”-ийн Хаан банкны 5009353520 тоот дансанд шилжүүлнэ.

6.3 Энэхүү гэрээний хугацаанд захиалгын үнийг талууд нэмэхгүй бөгөөд зайлшгүй нэмэх тохиолдолд талууд харилцан зөвшилцсөний үндсэн дээр өөрчлөлт оруулж болно.

### Долоо. Гэрээ хүчин төгөлдөр болох, нэмэлт өөрчлөлт оруулах, цуцлах, дуусгавар болгох, маргаан шийдвэрлэх

7.1 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.

7.2 Талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно. Нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэж, хоёр талын эрх бүхий хүмүүс гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.

7.3 Талуудын гэрээний үүргээ биелүүлээгүй, гаргаж өгсөн хуваарийн дагуу үйлчилгээг үзүүлээгүй, эсхүл зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд аль нэг талын санал болгосноор гэрээг цуцалж болно. Гэрээг цуцлах тухай хүсэлтээ хуанлийн 10 өдрөөс доошгүй хугацааны өмнө нөгөө талдаа шалтгааныг тодорхой дурьдаж бичгээр хүргүүлнэ.

7.4 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр хугацаанаас өмнө гэрээг дуусгавар болгож болно.

7.5 Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон аливаа асуудлыг харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэх ба хэрвээ тохиролцоонд хүрч чадаагүй нөхцөлд шүүхэд хандаж болно.

#### **Найм. Бусад зүйл**

8.1 Талуудын аль нэг өөрчлөн байгуулагдах, татан буугдах, итгэмжлэгдсэн төлөөлөгчид солигдох ямарваа нэгэн тохиолдолд энэхүү гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг түүний залгамжлагчид нь шилжин гэрээний хугацаа дуусгавар болох хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

8.2 Энэхүү гэрээг 2 хувь үйлдэх ба тус бүр хуулийн адил хүчинтэй.

#### **Гэрээг байгуулсан:**

“Эрдэс Баялаг Уул Уурхайн Бирж”

..... ХХК,ХК

Маркетингийн хэлтсийн дарга

..... ХЭЛТСИЙН .....

...../Б.Буяннэмэх/

...../ /

**Утас: 91927088 Факс: 70116009**

## ИВЭЭН ТЭТГЭХ БАГЦ ХУВИЛБАРУУД

Уул уурхайн бизнес эрхлэгч танай компани энэхүү чуулга уулзалтанд дараах 3 төрлөөр ивээн тэтгэж, бусад оролцогчдоосоо давуу талыг олох боломжтой. Үүнд :

### ПЛАТИНИУМ СПОНСОР (Platinum- 20.000 \$):

- ✓ Чайна майнинг клубын үндсэн гишүүн болно.
- ✓ Чайна Майнинг Клубын удирдах гишүүнд нэр дэвших эрх,
- ✓ Сар бүрийн Хятад улсад болох хөрөнгө оруулалтын чуулга уулзалтад төлбөргүй 3 онцгой гишүүнээр оролцох эрх,
- ✓ Компаний танилцуулга, логог Хятад улсад сар болгон зохиогдох хөрөнгө оруулалтын чуулга уулзалтад сурталчилах боломж,
- ✓ Эрдэс Баялаг Уул Уурхайн Биржийн үндсэн гишүүн болно.
- ✓ Чуулга уулзалтад төслөө бусад төслүүдийн эхэнд 20 минут тавих эрх
- ✓ Форумын Хятадын талын сурталчилгааны материал, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд, тайзан дээр Платиниум спонсор гэж компаний лого нэрийг байршуулах эрх
- ✓ Тусгай хөрөнгө оруулалтын бизнес уулзалт, хүлээн авалтад хүндэт зочноор орох эрх
- ✓ Чуулга уулзалтын үзэсгэлэнгий танхимд компаниа сурталчилах эрх
- ✓ Тусгайлан урьдчилан форумд оролцох 100 гаруй компаниудад төслийг дэлгэрэнгүйгээр танилцуулах эрх
- ✓ Форумын талаархи Монголын сурвалжлага, нэвтрүүлэг, нийтлэлд Платиниум спонсор хэмээн дурьдаж компани, төслийн талаархи танилцуулга мэдээллүүдийг хүргэх
- ✓ Монголын оролцож буй компаниудын төсөл, компаний танилцуулга Хятад, англи хэлээр хэвлэгдэх номд дэлгэрэнгүйгээр хамгийн эхэнд танилцуулах,

### АЛТАН СПОНСОР (Gold-10.000\$ )

- ✓ Чайна майнинг клубын үндсэн гишүүн болно.
- ✓ Сар бүрийн Хятад улсад болох хөрөнгө оруулалтын чуулга уулзалтад оролцох эрх
- ✓ Форумын Хятадын талын сурталчилгааны материал, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд, тайзан дээр Алтан спонсор гэж компаний лого нэрийг байршуулах эрх
- ✓ Чуулга уулзалтад 2 гишүүнийг оролцуулах эрх
- ✓ Эрдэс Баялаг Уул Уурхайн Биржийн гишүүн болох эрх
- ✓ Чуулга уулзалтад төслөө 10 минут илтгэл тавих эрх
- ✓ Чуулга уулзалтын үзэсгэлэнгий танхимд компаниа сурталчилах эрх
- ✓ Тусгайлан урьдчилан форумд оролцох 100 гаруй компаниудад төслөө танилцуулах эрх
- ✓ Форумын талаархи Монголын сурвалжлага, нэвтрүүлэг, нийтлэлд Алтан спонсор хэмээн дурьдаж компани, төслийн талаархи танилцуулга мэдээллүүдийг хүргэх
- ✓

- ✓ Хятад, англи хэлээр хэвлэгдэх Монголын оролцож буй компаниудын төсөл, компаний танилцуулга номд Платинум гишүүний дараа танилцуулах эрх

#### **МӨНГӨН СПОНСОР (Silver- 5.000 \$)**

- ✓ Чайна майнинг клубын үндсэн гишүүн болно.
- ✓ Сар бүрийн Хятад улсад болох хөрөнгө оруулалтын чуулга уулзалтад оролцох эрх
- ✓ Форумын Хятадын талын сурталчилгааны материал, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд, тайзан дээр Мөнгөн спонсор гэж компаний лого нэрийг байршуулах эрх
- ✓ Чуулга уулзалтад 1 гишүүнийг оролцуулах эрх
- ✓ Чуулга уулзалтад төслөө 6 минут илтгэл эрх
- ✓ Эрдэс Баялаг Уул Уурхайн Биржийн гишүүн болох эрх.
- ✓ Чуулга уулзалтын үзэсгэлэнгий танхимд компаниа сурталчилах эрх
- ✓ Тусгайлан урьдчилан форумд оролцох 100 гаруй компаниудад төслөө танилцуулах эрх
- ✓ Форумын талаархи Монголын сурвалжлага, нэвтрүүлэг, нийтлэлд Мөнгөн спонсор хэмээн дурьдаж компани, төслийн талаархи танилцуулга мэдээллүүдийг хүргэх
- ✓ Хятад, англи хэлээр хэвлэгдэх Монголын оролцож буй компаниудын төсөл, компаний танилцуулга номд Платинум, Алтан спонсорын дараа танилцуулах эрх.